



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/444

Ховд

“Цэвэрхэн наадацгаая” аяныг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,1,6 “а”, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн удирдамжийн дагуу аймгийн бүх сумуудын нутаг дэвсгэрт “Цэвэрхэн наадацгаая” аяныг 2019 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс 16-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. “Хандлагаа өөрчилж, Цэвэрхэн наадацгаая” аяныг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

Ц.Ганданповрон - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Гантөмөр - Жаргалант сумын Засаг дарга

Х.Баасанхүү - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

П.Эрдэнэчулуун - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Д.Эрдэнэчимэг - Мэргэжлийн хяналтын газрын эрүүл, ахуйн хяналтын улсын байцаагч

Д.Ганбаатар - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Zax A/444 Ch

02 02222

2.

С.Батмөнх - Хар-ус нуур орчмын улсын тусгай
хамгаалалттай газар нутгийн
хамгаалалтын захиргааны дарга

А.Энхзаяа - Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн дарга

Р.Энхсүрэн - Хар нуур-Ховд голын сав газрын
захиргааны дарга

Д.Даваахүү - Сум дундын ой ангийн дарга

А.Цэен-Ойдов - Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын мэргэжилтэн

Х.Алтантуяа – Аймгийн Засаг даргын Тамгын
газрын хэвлэлийн төлөөлөгч

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Д.Бөхболд - Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн

3. “Хандлагаа өөрчилж, Цэвэрхэн наадацгаая” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган, тусгагдсан арга хэмжээнүүдийг иргэд, олон нийтэд мэдээлэх, аяны тайлан мэдээг сумдаас авч нэгтгэн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжлахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ